



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 4/559

Мөрөн сум

Теле хяналтын төв байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5.1.2, 25.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 86-р тогтоол 86.1,86.2,86.3,86.4,86.5-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Монгол Улсын Засгийн газрын 86-р тогтоолын хэрэгжилт хангах хүрээнд Хөвсгөл аймагт Теле камер хяналтын төв байгуулах болсон тул Хөвсгөл аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн дэргэдэх төв болгон баталж мэргэжилтнүүдээ шалгаруулан авч, удирдлага арга зүйгээр хангаж үйл ажиллагааг тасалдуулалгүй ажиллахыг хэлтсийн дарга (Д.Сумаадагва)-д даалгасугай.

Хөвсгөл аймаг дахь Теле хяналтын төвийн ажилчдыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газрын дарга Хурандаа (Д.Мөнхжаргал)-д даалгасугай

Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ